## БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 09 сарын 02-ны өдөр Дугаар БА-223/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан-Уул дүүргийн 16 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 2 давхар, 3 блок, 280 хүүхдийн хүчин чадалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 16 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2025/08/04 огноо, 0003397 БАЗГ2025/0708 дугаар,

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: БП-03/72

2.3. Захиалагч: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ оноосон нэр, 9014001040 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5369622 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг 23 дугаар хороо, Арцатын аманд байрлах Нийслэлийн нутгийн захиргааны нэгдсэн цогцолбор барилгын Б блок 5 давхар, холбоо барих утас: 11-324249

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: ЗМК Глобал ХХК оноосон нэр, 9011423068 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5728266 регистрийн дугаар, БУ12-629/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Баянзүрх хотхон 110-02 тоот 88111991 холбоо барих утас,

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Бат проект ХХК оноосон нэр, 9011113047 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2773643 регистрийн дугаар, ЗТ19-583/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 6 дугаар, бага тойруу,26, 1-213 тоот холбоо барих утас:99249997

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЯЛ Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Нийслэлийн Боловсролын газар оноосон нэр, 9070003041 Улсын бүртгэлийн гэрчилгээний

дугаар, 9977065 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо, Багшийн хөгжлийн ордон 5 давхар, холбоо барих утас 70113039

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс

## Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 2 давхар, 3 блок, 280 хүүхдийн хүчин чадалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 7 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 32 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зоорьгүй 2 давхар, 3 блок, 280 хүүхдийн хүчин чадалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-Уул дүүргийн 16 дугаар хороо, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, зоорьгүй 2 давхар 3 блок 280 хүүхдийн хүчин чадалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга

Комиссын дарга:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Нийслэлийн Хөрөнгө оруулалтын
газрын Барилга захиалагчийн
хяналтын хэлтсийн дарга (Б.Ганзориг)

Нийслэлийн Хөрөнгө
Оруулалтын газар
5300622

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.
Объектын дугаар 851
Огноо 2015 он 09 сар 02 өдөр
Бүртгэсэн: О. Тикир
УЛААНБААТАР ХОТ ТТМ

ХАН УУЛ ДҮҮРГИЙН 16 ДУГААР ХОРОО, НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ЗАХИАЛГАТАЙ, 280 ХҮҮХДИЙН БАГА СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЦОГЦОЛБОР 2 ДАВХАР 3 БЛОК

БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ

КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАР
Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс

2025 оны 08 дугаар сарын 06 Улаанбаатар хот

Хан уул дүүргийн 16 дугаар хороо, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, 280 хүүхдийн бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор 2 давхар 3 блок барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан 2025 оны 08 сарын 06-ны өдрийн 12:00 цагт 16 гишүүний бүрэлдхүүнтэй эхэлж 14:30 цагт дуусав.

Хуралд:

| | |
|---|---|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: | А.Мөнгөн |
| 2. Хяналт шалгалтын газрын, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч: | Т.Цолмонтуяа |
| 3. Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч: | З.Очирпүрэв |
| 4. Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын албаны инженер: | Д.Гал-Эрдэнэ |
| 5. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны хэсгийн инженер: | О.Болорцэцэг |
| 6. УБДС ТӨХК-ийн БТТ-ийн ахлах инженер: | Э.Ундрахцогт |
| 7. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн: | Н.Даваадэмид |
| 8. Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын байцаагч: | Б.Дөл-Эрдэнэ |
| 9. Барилга хөгжлийн төв, Барилга, барилгын материалын үйлдвэрлэл баталгаажуулалтын хэлтсийн мэргэжилтэн: | О.Ундрах |
| 10. Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч: | Э.Шижиртуяа |
| 11. Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны ажилтан: | Б.Даваасүрэн |
| 12. ОСНААУГ-ийн ашиглалтын инженер: | Д.Гантуяа |
| 13. Зураг зохиогч, “Бат проект” ХХК-ийн автор: | Н.Наранчимэг |
| 14. Гүйцэтгэгч, “ЗМК ГЛОБАЛ” ХХК-ийн захирал: | А.Заяадэлгэр |

15. Нийслэлийн боловсролын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилга, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн: Д.Ирмүүнзаяа
16. Комиссын нарийн бичгийн дарга: Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн барилгын хяналтын инженер: Г.Буянжаргал

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан – 16
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 16

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хан Уул дүүргийн 16 дугаар хороо, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, 280 хүүхдийн бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор 2 давхар 3 блок барилгын ажлын гүйцэтгэлийг шалган ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газрын, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч: **Т.Цолмонтуяа**

- БНБД 11-04-16 барилгын ажилд зохиогчийн хяналт тавих дүрмийг баримтлан дүгнэлтийг шинэчлэн ирүүлэх
- БТХ-ийн 14.3, 14.6 чанарын баталгаа ирүүлнэ
- Гадна тоглоомын талбайг зураг төслийн дагуу тохижуулна /фото зургаар/ 3 байршилд
- ЭМС, БХБЯ-ны Сайд нарын хамтарсан тушаалын дагуу дотоод орчны шинжилгээг 3 цэгээс авч ирүүлнэ. /Гоёлын доторлогоо ашигласан өрөөнүүдээс/
- Хамгаалалтын горимд шилжүүлсэн баримт бичиг ирүүлнэ
- Ил, далд ажлын актанд суурийн ажлын арматур ф22 /хөндлөнгийн байгууллагын дүгнэлт үл эвдэх аргаар/ ф25 хийгдсэн эсэх
- Төсөвт өртөгт сургуулийн сандал ширээ ороогүй талаар төсөвчний тайлбар, албан бичиг төсөвт туссан тооны тоног төхөөрөмжүүдийг тулгах
- Гадна аваарын шатыг цас бороо тогтхооргүй, хөлдөж мөстөхөөргүй шийдлийг зургийн автортой зөвшилцөж бүгдийг засаж янзлаад гэрэл зургаар ирүүлэх
- Ашиглагч байгууллагад баримт бичгийг нэг хувь актаар хүлээлгэж өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна

Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч: **З.Очирпүрэв**

- Гадна ус, дулаан хангамжийн шугам сүлжээний ил, далд сорилт туршилтын актууд шалгуулах /узель/
- Нөөцийн сав угсраагүй талаар тайлбар
- Цэцэрлэгийн барилгын 1-р давхарт угсрагдсан халаалтын түгээх шугамын хаалтууд шаланд наалдаж хаах боломжгүй байгааг засварлах
- Цэцэрлэг, сургуулийн гал зуухны уур сорох АС-ны моторын дуу чимээ их байгааг багасгах арга хэмжээ авах
- Халаалт, хэрэглээний халуун хүйтэн усны түгээлтийн шугаманд таслах хаалтууд нэмж угсрах
- Агаар сэлгэлтийн ердийн системүүдийн /анги танхим/ сорилтын багажаар шалгаж бичлэгээр баталгаажуулан шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын албаны инженер: **Д.Гал-Эрдэнэ**

- 0,4кв ерөнхий шитэнд автомат сэлгэх залгах төхөөрөмжтэй самбарын угсралтын ажлыг гүйцээн хийх
- Техникийн нөхцөлийн 5.5 дахь заалтыг хангаж ажиллах
- Аянга хүлээн авах антень суурьлуулах
- 00-ын өрөө болон гал тогооны өрөөнүүдэд хамгаалалттай розетка суурьлуулах
- Залгах зөвшөөрөл болон 630ква трансформатор хүлээлгэн өгсөн акт нөхөж үзүүлэх
- Ажлын зураг нахаж үзүүлэх /0,4кв/

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн: **Н.Даваадэмид**

- Холбооны самбар дахь шугамыг вирк зүүж хаягжуулах

- Гадна холбооны сувагчлалыг серверийн өрөөнд ил гаргаж сүлжээний кабель шугам орж ирэхэд бэлэн болгох

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Барилга хөгжлийн төв, Барилга, барилгын материалын үйлдвэрлэл баталгаажуулалтын хэлтсийн мэргэжилтэн: **О.Ундрах**

- Аяган суурийн холбоос дам нуруу болон хамар ханын суурь хийсэн далд ажлын акт, фото зураг нөхөж үзүүлэх
- Спорт заалны металл прогоны холбоос-1 хийгдсэн эсэх акт, фото зураг үзүүлэх

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу гэрээ байгуулсан төсвийн хүрээнд норм, нормативын төлбөрийг төлөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх албаны хэсгийн инженер: **О.Болорцэцэг**

- Гадна цэвэр усны худаг цэвэрлэж таг тавих
- Гадна цэвэр усны худагт байгаа ф15мм сосанк таслах, тоолуурын өмнөх сосанк таслах
- Бохир усны насосны техник ашиглалтын пасспорт, насосны бичиг баримт шалгуулах
- Гадна бохир усны худагт ажлын талбайг засах, гаргалгаа шугаманд отвот хийж эргүүлэх
- Гүйцэтгэлийн зураг мэдээллийн санд оруулсан акт шалгуулах
- Бохир усны шугам угсралт уклон алдсан эсэх, дуран явуулж фото зургаар баталгаажуулах
- Ундны уснаас сорьц шинжилгээ авч дүгнэлт гаргуулах MNS0900:2018 хангах
- Гадна цэвэр усны шугам сүлжээнд баталгаа бичиг өгөх
- Бохир усны шугаманд ган футлиар хийсэн фото зураг шалгуулах
- Нөөцийн сав угсраагүй тайлбар өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

УБДС ТӨХК-ийн БТТ-ийн ахлах инженер: **Э.Ундрахцогт**

- Гадна дулааны худаг цэвэрлэж худаг доторхи шугам дулаалах
- Холигч насосны температур тохируулах автомат зөөж зөв суурьлуулах. Холигч насосонд ус буулгагч хийх
- ХХУ-ны бойлурын холболтын схем өөрчилж зөв болгох
- ХХУ залгаж шалгуулах
- Гадна шугам, холигч узель, дотор системийн шахалтыг актууд дээр хянагч байгууллагаар шалгуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын ахлах архивч: **Э.Шижиртуяа**

- Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн тэмдэглэлийг баталгаажуулах
- Архивд баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримт бичгийг бүрэн бүрдүүлэх, хуудас дугаарлах, дотоод товъёг үйлдэх
- Баримт бичиг болон ажлын зургийн эх хувийг архивд хүлээлгэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны ажилтан: **Б.Даваасүрэн**

- Гадна авто зогсоолд ХБИ -д зориулсан зогсоолыг босоо болон хэвтээ тэмдэглэгээтэй зогсоолыг стандартын дагуу хийх
- Зүүн талын талбайруу орох хэсэгт пандусыг стандартын дагуу хийх
- Үүдний орох хэсгийн налуу замыг стандартын дагуу болгож засах
- Налуу замуудын төгсгөл хэсгийн ирмэгүүдийг зөв болгож засах
- Цэцэрлэгийн ажилчдын АЦӨ-д ХБИ-д зориулсан тусгай тоноглолоор тоноглох
- Цэцэрлэгийн ангиудын АЦӨ-ийн 1ш суултуурыг ХБХ-д зориулан тоноглох

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төслийн хяналтын байцаагч: **Б.Дөл-Эрдэнэ**

- Гал унтраах даралтын хоолой техникийн шаардлага MNS6576:2016 стандартын дагуу гал унтраах даралтын хоолойн хошуу тотго хомут солих, тэмдэглэгээ хийх
- Шалын дохиоллын утаа мэдрэгчийн таг авах
- Аврах зам гарцын тэмдэг тэмдэглэгээг хийж байрлуулах
- Гадна дулаалгад ашигласан материалын шинжилгээний бичиг, дүгнэлт нөхөж үзүүлэх. 2022.08.31-ний өдрийн 249/04-132 дүгнэлтийн 2-р хэсгийн 1 дэх заалт захиалагч, автор нар албан бичиг дүгнэлт гаргаж өгөх
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга төлөвлөлт, зрөнхий боловсролын байгууллагын барилга төлөвлөлт БНБД-ийн дагуу гал унтраах автомашины орц гарцыг 2-оос доошгүй байхаар төлөвлөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

ОСНААУГ-ийн ашиглалтын инженер: **Д.Гантуяа**

- Халаалтын температур мэдрэгчийг зөв байрлалд суурьлуулах
- Халаалтын өгөх, буцах шугам ус буулгах хаалт суурьлуулах
- ХХУ-ны ялтсан дулаан солилцуурын холболтыг зөв болгож өөрчлөх
- Ус буулгах зайлуулах траптай болгох
- Барилга дотор халаалтын гол шугамнаас салбар шугам огтлож байгаа шугам таслах хаалт байхгүй, таслах хаалт суурьлуулах
- Гадна бохир усны худагт уклон хийгдээгүй, цэвэрлэгээ хийх
- Гадна дулааны худгийн дулаалга гүйцэт хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн боловсролын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилга, хөрөнгө оруулалтын мэргэжилтэн: **Д.Ирмүүнзаяа**

- Дотор шилэн хаалга, ханaнд хамгаалалтын хуулга наах

- Сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийн байрлах цахилгааны тэжээл шилжүүлж тааруулах
- Гадна тохижилт тоглоом хийх
- Гадна талбайн өндөржилттэй хэсэгт хашаа хамгаалалт хийх
- Баруун хойд хашааны хаалганы хэсгийг янзалж ус зайлуулах хоолойг зорчих хэсгээс гаргах
- Цахилгаан дулааны төлбөр тооцоо дуусгах
- Барилгын хувийн хэрэг үүсгэж өгөх, ашиглашч байгууллагад барилгын зураг төсөв, холбогдох материал нэг хувь хуулбарлаж өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

“БАТ ПРОЕКТ” ХХК-ийн автор: **Н.Наранчимэг**

- ОБ-н үед ашиглах 2 шатны доод хэсгийг будах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын Барилга захиалагчийн хяналтын хэлтсийн барилгын хяналтын инженер: **Г.Буянжаргал**

- Барилгын тухай хуулийн 14.3 болон 14.6-д заасны дагуу чанарын баталгаа гаргах
- Гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтийг хангуулах
- Ашиглагчтай хүлээлцэх акт үйлдэх
- Нийслэлийн өмчийн газарт хүлээлгэн өгөхөөр өмчийн задаргаа гаргаж өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна.

“ЗМК ГЛОБАЛ” ХХК-ийн захирал: **А.Заяадэлгэр**

- Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авах саналтай байна

Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: **А.Мөнгөн**

- Гүйцэтгэгч БТХ-н дагуу чанарын баталгаа албан тоот ирүүлэх
- Зохиогч дүгнэлтээ БНБД 11-04-16-н дагуу бичих

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Хан Уул дүүргийн 16 дугаар хороо, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, 280 хүүхдийн цэцэрлэг бага сургуулийн 2 давхар 3 блок цогцолбор

барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэж, баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АШИГЛАЛТ, БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ: А.МӨНГӨН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА: Б.ГАНЗОРИГ